

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-12</i>
<hr/>	
<i>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт</i>	<i>3-12</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 04 дүгээр сарын 12-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 43 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Б.Энх-Амгалан;  
Чөлөөтэй: Ц.Сандаг-Очир, Н.Учрал, Б.Энхбаяр.

**Нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг танилцуулав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Э.Бат-Амгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Сүхбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ш.Адьшаа, Ц.Сэргэлэн нар үг хэлэв.

**Ж.Сүхбаатар:** 1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 9  
Бүгд: 12  
25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд

огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 10  
Бүгд: 12  
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 40 минут үргэлжилж, 19 гишүүнээс 13 гишүүн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 23 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ж.СҮХБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим 10 цаг 43 минут

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Сүхбаатар:** Энхбаяр дарга өнөөдрийн хуралдааныг удирдах боломжгүй, чөлөө авсан байгаа учраас миний бие удирдахаар болсон байна.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. 11 гишүүн ирсэн байна. Адьшаа гишүүн ирсэн байна. Алтанхуяг гишүүн ирцэд орсон байна. Бат-Амгалан гишүүн ирсэн байна. Бямбацогт гишүүн ирсэн байна. Мөнхбаатар гишүүн ирсэн байна. Ц.Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Нямбаатар гишүүн ирсэн. Пүрэвдорж гишүүн ирсэн. Раднаасэд гишүүн ирсэн. Сүхбаатар гишүүн ирсэн. Сэргэлэн гишүүн ирсэн. Ингээд ирц ийм байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

*Хэлэлцэх асуудал нэг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлт.*

Энэ дүгнэлтийг хэлэлцэхээр өнөөдөр орсон байгаа. Та бүхэн мэдэж байгаа. Хуульд заасан хугацаатай учраас

энэ асуудал яаралтай хэлэлцэх болж байгаа.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай ийм асуудал байгаа.

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.1-д цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах гэж заасан.

Цэцийн дүгнэлтийг гишүүддээ тараасан байгаа. Өнөөдрийн гол хэлэлцэх гэж байгаа дүгнэлт дээр Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр миний бие томилогдсон. Ингээд энэ дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

Гол агуулга нь ер нь юу юм бэ гэхээр Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн 41.2-т “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.3-т заасан тодорхой тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1, 50 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, заалтыг зөрчсөн гэж үзэж Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Батмөнх цэцэд хандаж ийм агуулгатай мэдээллийг ирүүлсэн.

Энэ мэдээлэл дотор гол юм нь ямар агуулгатай вэ гэхээр гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан гэж заасан ба шүүхийн

шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон ч тухайн асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэхээр дээрх заалтад заасан нь шүүхийн шийдвэр хэрэгжихэд саад учруулж байна. Өөрөөр хэлбэл хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт нь тухайн шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолыг хэлэлцэхээр оруулахад төлөөлөгчид нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 39.1.3 дахь заалтын дагуу хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт асууж, хариулт авна. Санал, дүгнэлт гаргах, санал хураалгах эрхтэй байхаар заасан буюу энэ эрхийнхээ хүрээнд тухайн шүүхийн шийтгэх тогтоолтой холбоотой асуудлыг дурын төлөөлөгч хэлэлцэх асуудлаас хойшлуулах санал гаргаж, үүний дагуу санал хураалт явуулж олонхын саналаар хэдэн ч удаа хойшлуулж болохоор нөхцөл үүссэн байна. Тэгээд ийм байхаар шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байдлаар яваад байж болох нь. Тийм учраас энэ нь Үндсэн хууль зөрчиж байна гэсэн ийм агуулгатай юм ирүүлсэн.

Би итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд миний явуулсан хариулт бол Хурлын төлөөлөгч бол тухайн дүүргийн иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлдэг, тэдний төлөөлөгч. Мандат авдаг. Хугацаанаас өмнө дуусгавар болох асуудал бол иргэдийн өөрийнх нь сонгох төлөөлүүлэх эрхтэй нь холбогддог учраас энэ мандатыг хугацаанаас цуцлах асуудлыг тухайн субъект өөрөө хэлэлцэн шийдвэрлэдэг. Тухайлах юм бол манай Улсын Их Хурлын гишүүдийг гэхэд хэдийгээр гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоосон ч гэсэн Улсын Их Хурал энийг өөрөө хүлээж авч шийдвэрлэдэг. Үндсэн хуульд зааснаар бол энийг татах ажлыг бол ингэж хийдэг. Тэгэхээр шүүх бол мандатыг шууд эвддэггүй. Гэм буруутайд тооцоод явчихдаг. Тэр мандатыг иргэдийн төлөөлж байгаа эрхийг цуцлах эрх нь тухайн төлөөллийн институт нь өөрөө эдэлдэг нь олон улсын жишиг. Монголд ч гэсэн ингээд

хуульчилсан. Ингээд хуулийн дагуу ингээд хуульчилсан байсан зүйл дээр буруу ойлгосон уу, аль талаас бодсон ямар ч байсан энийг шүүх эрх мэдэлд халдсан, шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцэж байгаа юм шигээр ойлгоод цэц бол зөрчсөн гэсэн дүгнэлт гаргаад, иргэний мэдээллийг хангаад явчихсан байна. Тэгээд хэрвээ цэцийн шууд ингэж ойлгосноор явчих юм бол шууд сонгогдсон төлөөлөгчийн мандатыг шууд шүүх цуцалж болдог юм шиг юм ойлгогдохоор байгаад байгаа юм. Тэгэхээр яах вэ энэ дээр бид зөрчсөн гэдэг асуудал дээр бол хэрвээ хүлээж авна гэвэл засаад дахиад хийнэ. Гэхдээ хийсэн ч гэсэн ялгаагүй засаад ч байх юм байхгүй л дээ. Ер нь агуулгын хувьд тодруулаад өөрчилнө. Хийсэн ч гэсэн ялгаа байхгүй л нөгөө Их Хурлын гишүүнийхээ өөрчилдөг огцуулах тогтоол гаргана гэдгээр өөрчлөөд бичих боломж байгаа юм. Гэхдээ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд миний хувьд энийг хүлээн зөвшөөрөөгүй тайлбараа явуулсан. Тэгээд энэ дээр цэцийн ийм дүгнэлт гарсан. Энэ цэцийн дүгнэлтийн харах юм бол та бүхэн ч гэсэн харсан байх. Буруу ойлгосон юм уу, эсвэл яасан юм. Үндэслэл нь бол сайн ойлгогдохгүй байгаа юм. Танилцуулгыг товч хийхэд ийм байна.

Асуух асуулттай гишүүд нэрсээ өгөх үү. Адьяаа гишүүн орох уу. 4 гишүүнээр нэр тасаллаа. Мөнхцэцэг, Мөнхбаатар, Бат-Амгалан, Адьяаа. Ц.Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 41.1, 41.2 дахь заалтуудыг яг энэ хууль хэрэглээний процесс дээр дутуу ойлгосон эсвэл энийг арай өөрөөр тайлбарласан байх магадлалтай байна л даа. Цэцийн дүгнэлтийг харахад бол 41.2-оор буюу гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоолоор батлагдсан төлөөлөгчийг огцуулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ гэсэн нь шүүх эрх мэдэлд

халдсан байна гэж тайлбарлаад байгаа юм. Цэцэд өргөдөл гаргасан Батмөнх иргэний мэдээлэл дээр ч гэсэн тэгж байх шиг байна. Гэтэл яг энийг дахиад хууль руугаа харахаар 41.1 дээр угаасаа иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх дараах үндэслэлээр хугацаанаас өмнө дуусгавар болно гээд заалтууд байгаа. Тэгэхээр уг нь бол 41.1, 41.2-ыг харахаар энэ дээр бол шүүх засаглалын эрхэд халдсан гэдэг юм уу эсвэл тухайн гэмт хэрэг үйлдсэн төлөөлөгчийг чөлөөлөхгүй байх үндэслэл харагдахгүй байгаа юм. Гэхдээ нэгэнт маргаан үүссэн, цэц бол 41.1.3 бол Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзсэн учраас бид нарт нэг ийм гарц байж болох юм.

41.2 дээр байгаа 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцируулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэдэг энэ заалт дээр бага зэргийн найруулгын гэдэг юм уу ийм засвар хийх шаардлагатай болов уу гэж харж байна. Өөрөөр хэлбэл бид нар цэцийн дүгнэлтийг хүлээж аваад энэ хуульдаа өөрчлөлт оруулъя. Өмнөх хууль дээр энэ тохиолдолд огцируулах тухай тогтоол гаргана гэж байсан гэж байгаа. Тэгэхээр тиймэрхүү байдлаар засаад өгвөл хууль хэрэглээний маргаан үүсэхгүй болов уу гэж бодож байна.

**Ж.Сүхбаатар:** Асуулт асууж байгаа. Дараа нь үг хэлж болно. Үг байгаа. Тэгэхээр ер нь бид нарын гишүүдийн хувьд бодох юм нь хүлээж аваад гэхээр уг нь нээх зөрчсөн юм бол байхгүй. Найруулгыг нь тодруулж бичээд явах асуудал. Уг нь түрүүний саяны уншдаг л даа. 41.1.3-т гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан бол хугацаанаас өмнө дуусгавар болно гээд 41.1.1 дээр байгаа. Зүгээр энэ дээр 41.2 дээр хэлэлцэж шийдвэрлэнэ гэдэг дээр хэлэлцэж байгаад янз бүрийн байдлаар хойшлуулах юм шиг болоод. Тэгэхээр Мөнхцэцэг гишүүний хэлдгээр хэрвээ хүлээж авбал яах вэ огцируулах тогтоол гаргана гээд Их

Хурлын гишүүнтэйгээ адилхан яг хийчхэж болно л доо. Тэрнээс биш зарчмын хувьд тэр цэцийн тэр иргэний мэдээлэл дээр байдаг шүүхийн шийдвэр эцсийн байна гэдгийг зөрчсөн гэдэг логик бол биш байхгүй юу. Энэ дээр цэцийн үндэслэл дүгнэлт нь бол чир дутагдалтай байгаа юм. Энийг харахаар. Тэгэхээр энэ дээр ийм вариант бол бий. Гэхдээ итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд би бол энийг хүлээн зөвшөөрөөгүй л дээ.

Мөнхбаатар гишүүн асуултаа асууя.

**Л.Мөнхбаатар:** Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүй байх нь зүйтэй гэж би харж байгаа юм. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн тодорхой заалт байгаа. 41 дүгээр зүйл. Энэ бол иргэдийн Төлөөлөгч гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан бол түүнийг огцируулах асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх нь Үндсэн хууль зөрчиж байна гэж байгаа юм. Энэ бол шүүх эрх мэдлийн шүүхийн хүчин төгөлдөр эцсийн шийдвэртэй холбоотой асуудал биш гэж би бодож байгаа юм. Шүүхийн шийдвэр эцсийнх байна. Хүчин төгөлдөр ойлгомжтой. Энэ бол огцируулах эсэх асуудал биш шүү дээ. Огцируулах асуудлыг хэлэлцлээ гэж байгаа юм. Огцируулах эсэх асуудлыг хэлэлцэх юм бол мэдээж энэ чинь өөрөө шүүхийн шийдвэрийг хэлэлцэж байгаа мэт болоод явчих юм. Зөв, бурууг нь хэлэлцэж байгаа мэт харагдана. Огцируулах асуудлыг хэлэлцэхгүй орхичих юм бол нөгөө тухайн тойргийн төлөөллийг хангах, дараа нь нөхөн сонгууль явуулах, төлөөллийг хангах энэ эрх нь өөрөө орхигдчих юм байгаа юм. Ийм учраас энийг хэрэгтэй бол дараа нь огцируулаад, дараагийнхаа нөхөн сонгуулиа явдаг энэ эрх зүйн боломжийг нээж өгч байгаа заалт гэж би хараад байгаа юм. Ийм учраас цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүйгээр явахад

энэ бол ойлгомжтой. Нөгөөтээгүүр Улсын Их Хурлын гишүүнийг ч гэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарах юм бол Улсын Их Хурал өөрөө хэлэлцээд, тогтоол гаргаад чөлөөлж байгаа шүү дээ. Ийм Үндсэн хуулийн зохицуулалт байгаа. Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох заалтууд байгаад байгаа юм. Ийм учраас ингээд явбал яасан юм гэсэн бодолтой байна. Ер нь бол хэрвээ огцруулах эсэх асуудлаар хэрвээ иргэдийн хурал эрх мэдлээ хэтрүүлэн шийдвэр гаргасан байх юм бол тэрийг нь шийддэг Үндсэн хуулийн болоод Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль бас энэ заалтууд нь байж байгаа юм. Угаасаа л хууль, эрх зүйн хувьд энийг шийдээд явах бүрэн боломжтой зүйл байгаа юм. Ер нь л бид нар бүгдээрээ нэг ойлголт дээр тогтох хэрэгтэй. Шүүхийн шийдвэрийн зөв, бурууг хэлэлцэхгүй. Энэ бол төлөөллийг хангахын тулд тухайн хүнийг тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах асуудлыг шийдээд төлөөллийг нь хангах нөхөн сонгууль явуулах боломжийг нь бүрдүүлж байгаа юм гэж Их Хурал ойлгоод явах нь зүйтэй байх. Нөгөөтээгүүр бид баталсан хууль, тогтоомжоо бол хамгаалаад явах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байна.

**Ж.Сүхбаатар:** Үг хэлсэнд тооцож болох байх. Бат-Амгалан гишүүн.

**Э.Бат-Амгалан:** Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авахгүй нь зүйтэй байх гэж бодож байгаа. Ямар учиртай ийм юм ярьж байна гэвэл нэгдүгээрт нэгдсэн Монгол Улс, Үндсэн хуультай орон. Бүх шатандаа хуулийг нэг мөр ойлгож, нэг мөр явах ёстой гэж тооцож байгаа. Улсын Их Хурал дээр ч тэр, Нийслэл, аймаг, орон нутаг ер нь бүх шатны төлөөллийн байгууллагууд маань нэгдсэн нэг ойлголттой явах хэрэгтэй. Сая Улсын Их Хурал дээр бас л санал хураалтууд яваад, гишүүдээ авч үлдэх, явуулах энэ асуудал дээр орсон. Яг

түүнтэй адилхан ийм кэйс байгаа л гэж зүгээр энгийн иргэд ойлгохоор ярихад энэ тал дээр бол саналтай байгаа.

Хоёрдугаарт, мэдээж маргаан хянан шийдвэрлэхэд оролцож байгаа талууд бүгд л бие биеийнхээ, өөрсдийнхөө гаргаж ирсэн дүгнэлтүүд, тайлбарууд өгч байгаа байх. Би Сүхбаатар гишүүнээс нэг асуулт асууя. Мэдээж нөгөө талаас Батмөнх иргэний гаргасан энэ гомдол дээр 50 дугаар зүйлийн 2 дээр яах вэ зүгээр шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх бусад этгээд заавал биелүүлнэ гээд тус тус заасан байгаа. Бусад этгээд гэдэгтэй яг Улсын Их Хурлыг төлөөлж орсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд энийг яг юу гэж ойлгож байна. Бусад этгээд гэдэг нь дотор нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь орох юм уу, орохгүй юм уу. Энэ дээр ямар тайлбар авсан. Яг энэ жижиг кэйс дээр тасдаж тайлбар тавьсан уу гэдэг ийм асуулт асууя. Дараа нь саналаа хэлье.

**Ж.Сүхбаатар:** Би бол бичгээр явуулсан байсан. Таны саяны сүүлийн хэлдэг Үндсэн хуулийн заалт бол бүх шүүх бусад этгээд гэдэг нь бол шүүхээс гадна бусад иргэн, байгууллага хэн боловч заавал биелүүлнэ гэсэн утга л даа. Тэгэхээр яах вэ манай хуульчилсан хуультай бол нэг буруу юм нь бол шүүхийн эцсийн шийдвэр гарчхаад байхад биелүүлэхгүй яваад байж болохоор байна гээд иргэн мэдээлэлдээ дурдсан. Тэрийг бид нар тийм нөхцөл бүрдүүлсэн байдлаар ингээд тайлбараа өгчихсөн байгаа. Тэрийг нь яг тэгээд цэц хангаад гаргасан. Тэр нь бол уг нь тийм биш байгаа байхгүй юу. Шүүх тэртээ тэргүй гэм буруутайд тооцох үүргээ биелүүлчихнэ. Тэгэхээр шүүхийн шийдвэр биелүүлэх гэдэг нь цуцал гэдэг шийдвэрийг шүүх гаргахгүй шүү дээ. Төлөөлөгчийн эрхийг цуцал гэж. Тэртээ тэргүй хуульд энэ хуульд ч заасан. Гэм буруутайд тооцсон бол хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно гээд заасан.

Тэгэхээр иргэдийн Хурал хэлэлцэх замаараа хойшлуулсаар байгаад нөгөө хүнийг гэж буруутайд тооцсон ч гэсэн аваад яваад байж болох ийм хийдэл байна гэдгээр нөгөөх нь тайлбарласан. Тэрийг энэ Дээд шүүхийн эцсийн шийдвэр биелэхгүй байна гээд шийднэ шүү дээ. Дээд шүүхийн эцсийн шийдвэр бол гармагцаа л хүчин төгөлдөр болж байгаа шүү дээ. Тэрийг чинь иргэдийн Хурал биелүүлэхгүй яваад байх юм байхгүй. Түрүүн Мөнхбаатар даргын хэлээд байгаа шиг асуудал ярих юм бол биелүүлэх яваад байгаа хүмүүс чинь бас л хууль зөрчсөн гээд асуудалд орох асуудал үүснэ шүү дээ. Иргэдийн Хурлын дарга яагаад хэлэлцүүлэхгүй байгаа юм гэдэг ч юм уу, хэн нэгэн биелүүлэхгүй бол ч гэдэг юм уу. Тэгэхээр бусад хуулийн механизмууд нь бол байгаа юм. Тэгэхээр энэ түрүүн манай зарим гишүүд бол хүлээж авахгүй явбал яасан юм гэж байна. Хүлээж аваад засна гэвэл Их Хурлын гишүүдийнх ч гэсэн ялгаагүй шүү дээ. Гэм буруутайд тооцсон ч гэсэн Их Хурал ч гэсэн гэм буруутайд тооцсон хүнийг чинь шүүхийн шийдвэрийн дагуу яв гэдэггүй шүү дээ. Тэр хүний гишүүний бүрэн эрхийг нь цуцлахын тулд Их Хурлаараа яриад тогтоол гаргадаг. Бид нар яг л тийм зарчмаар бодоод энийг томъёолсон. Гэхдээ тэр дээр нэг хэлэлцэнэ гэдэг үг дээр акцент өгөөд хэлэлцэх замаар янз бүрийн байдал болгох гээд байна. Тэгвэл тэрийг нь шууд огцруулах тогтоол гаргана гээд зааж өгч болох талтай ийм л тодруулж болох юм байгаа юм. Тэгэхээр ийм л нэг зөрүүтэй юм байгаа юм. Яг цэцийн дүгнэлтийг шууд хүлээгээд авахаар нэг тийм буруу байсан юм шиг болох гээд. Тэгтэл яг үнэндээ нэгжийнхээ хуулийн тэр агуулга бол мэргэжлийн хүмүүс угаасаа л энийг томъёолсон асуудал байхгүй юу. Тэгээд буруу хийсэн юм шиг ойлгогдох гээд байгаа юм. Тэгэхээр Мөнхбаатар гишүүн, Бат-Амгалан гишүүн 2-ын хэлээд байгаа хүлээж авахгүй байя гэдэг бол бас л манай гишүүдийн хувьд шийдээд явах боломжтой. Би угаасаа өөрөө итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бол

тэгж үзсэн. Гэхдээ бас Мөнхцэцэг гишүүн хэлж байна л даа. Цаг алдалгүй хүлээж аваад, арай тодруулаад найруулгын юм хийвэл хийчих юм гээд хэлж байна. Гэхдээ сая Мөнхбаатар гишүүн зарчмын асуудал гэж үзээд байна. Ингээд энэ юм дээрээ Их Хурал байх нь зүйтэй гэж байна. Тэгэхээр манай гишүүд саналаа өгөхдөө энийг бодолцоно биз гэж л бодож байна.

Бат-Амгалан гишүүн.

**Э.Бат-Амгалан:** Тодруулъя. Сүхбаатар гишүүн өөрөө сая яг хэллээ л дээ. Ер нь энэ маргаан чинь бас л аль аль талдаа л асуудалтай байгаа юм. Яг саяны кейс гараад хэлэлцэнэ гэж байгаа юм. Хэлэлцээд ямар нэгэн байдлаар хойшлуулаад яваад байвал яг ямар үр дагавар үүсэх вэ. Энэ дээр ер нь та цэц дээр ямар нэгэн тайлбар бичиж өгсөн, тайлбар тавьсан юм байгаа юу. Яг ингээд ямар нэгэн шалтгаанаар хойшлогдоод ирц хүрдэггүй ч юм уу, эсвэл хойшлуулдаг ч юм уу. Ийм тохиолдолд яг яах юм. Та өөрөө сая хэллээ шүү дээ. Ийм кейс гарахыг бас үгүйсгэхгүй л дээ.

**Ж.Сүхбаатар:** Ийм кейс гарахыг үгүйсгэхгүй. Гэхдээ манай Их Хурлын хуульд ч гэсэн гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг чинь хэлэлцдэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байж гишүүд илээр санал хураадаг. Тэгэхээр хэлэлцэхэд Төрийн байгуулалтын байнгын хороо ч гэсэн хуралдахгүй яваад байж болно шүү дээ. Тэр логикоор бол Төрийн байгуулалтын байнгын хороо тодорхой хугацаанд хуралдахгүй, ирц бүрдэхгүй ч гэдэг юм уу. Гэхдээ тэр тохиолдол ямар асуудал буюу ийм эс үйлдэхүй дээр тухайн албан тушаалтнууд хамтын удирдлагатай байгаа төлөөлөгчдийн хариуцлагын асуудал байхгүй юу. Ёс зүйн асуудал сөхөгдөнө. Тэр байгууллагыг толгойлж байгаа хүмүүсийн асуудал сөхөгдөнө шүү дээ. Тэрнээс энэ нь тийм



байх боломжтой байна гээд шууд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болохоор нь шууд бүрэн эрхийг нь цуцалж болохгүй л байхгүй юу. Төлөөлөх мандатыг нь.

Тэгэхээр тэр дээр энэ агуулга дээр харахад төлөөлөх мандатыг шууд цуцалж байх ёстой юм шигээр ойлгуулчхаж байгаа байхгүй юу. Тэгэхээр манай Их Хурлын тухай хууль гишүүдийн юм чинь яг энэ төлөөлөгч гэдэг чинь бид нар адилхан шүү дээ. Бид бол ард түмнийг төлөөлдөг. Тухай иргэдийн төлөөлөгч нар бол тухайн тойргийн иргэдийг л төлөөлдөг ялгаатай болохоос биш бид нар аль аль нь төлөөлөгч нар. Тэгэхээр бид нарын хууль зүйн журам бол адилхан л байх ёстой. Тэгэхээр манай энэ нэгжийн хуулийн зарчим бол Их Хурлынхаа гишүүдийн зарчим, журамтай адилхан журамлагдсан байгаа.

Тэгэхээр энэ дээр уг нь бол тэгвэл яах юм гээд кейс яриад байхаар тэр хүмүүс, тэгэхээр чинь Их Хурал дээр тэгвэл бид нар яаж хэлэлцэхгүй шууд шийдвэр гаргах юм уу. Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж л байгаа шүү дээ. Хүссэн хүсээгүй. Хэдийгээр хэчнээн ч тэр шүүх гэм буруутайд тооцсон ч гэсэн хэлэлцэж л таарч байгаа байхгүй юу. Тэр байтугай энэ даирамд хэлэхэд Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч асан Трамп дээр асуудал гарч байгаа байхгүй юу. Яаж байна гэхээр одоо Трамп гэм буруутайд буруутгагдаад явж байгаад хэрвээ буруутайд тооцчихвол шүүхийн шийдвэр гараад ял авчихвал энэ хүн Ерөнхийлөгчид өрсөлдөх боломжтой юу гэхээр их сонин юм хэлж байгаа шүү дээ. Америкийн профессорууд. Үндсэн хуульд ял авсан, гэм буруутайд тооцсон хүн өрсөлдөж болохгүй гэсэн заалт байхгүй. Байхгүй учраас шоронд орсон ч тэр хүн нэр дэвшээд, сонгуульд ялж болно гэж тайлбарлаж байгаа. Тэр нь яасан гэхээр дээр нь парламентын эрх зүйн хичээл дээр ч гэсэн заагддаг юм юу гэхээр

онолын хувьд парламентын гишүүн хүн шоронгоос ажилдаа явж болно гэж үздэг.

Төлөөлөх мандатыг нь цуцлах үндэслэл байж болохгүй. Одоо жишээлбэл бүр сонин үндэслэлийг нь гаргаж тавих юм бол тухайн байгууллага цуцлаагүй ч гэсэн тэр хүнийг гэм буруутайд тооцож шоронд хийлээ гэхэд төлөөлөгч шоронд байх үедээ ажлаа ямар нэгэн байдлаар явуулж болох ёстой гэдэг хүртэл тийм гаргалгаанууд байдаг. Тэгэхээр энэ чинь өөрөө бас хүмүүсийн хувьд сонин юм шиг боловч өөрөө тийм мандатын парламентын буюу эсвэл тухайн иргэдийн төлөөллийн мандат гэдэг бол өөрөө тийм хүчтэй зүйл байхгүй юу даа хамгийн гол нь. Тэгэхээр энэ бол зүгээр тийм учраас шууд энэ дээр цэцийн гарч байгаа дүгнэлт нь бол жишээлбэл яг энэ онолынх нь суурь зарчмаар нь аваад үзэх юм бол энэ бол энэтэй нийцэхгүй л байгаа юм. Ер нь бол одоо Трампыг тойрсон юм чинь тийм сонин болж байгаа шүү дээ. Яагаад гэвэл хүний сонгогдох эрхийг хэн нэгэн хязгаарлах ёсгүй гэж байгаа байхгүй юу. Ганц тохиолдолд хязгаарлана гэж байгаа. Тэр нь юу юм гэхээр үймээн, самуун бослого, төрийн эсрэг юм явсан юм дээр бол хязгаарлаж болдог юм байдаг гэдэг ч юм уу.

Тэгэхээр энэ бол нэг талдаа цэцийн гаргасан юмыг далимдуулаад хэлэхэд цаашидаа энэ иргэдийн төлөөлөгчид, ард түмний төлөөлөгчдийн мандатын асуудал, халдашгүй байдал гээд сүүлийн үед их яригдаад байна шүү дээ. Халдашгүй байдлыг тойроод иргэд ч гэсэн энийг цуцал, алга болго гэдэг боловч энэ чинь анх францын хувьсгалын дараа хаан парламент 2-ын хооронд зөрчилдөөн үүсээд, тэгээд ард түмний төлөөлөгчид эрхээ хамгаалахын тулд, мөрдөн шүүлт янз бүрийн хавчлагаас хамгаалагдахын тулд төлөөлөгчийн мандатыг хамгаалах үүднээс энэ халдашгүй байдлын ойлголт улам хүчтэй гарч ирсэн. Тэгээд энэ цаад

утгаар нь ярих юм бол эмнитет гэдэг юмтай холбоотой болчхоод байгаа юм л даа. Ганцхан Их Хурлын гишүүдийн дархлаа гэдэг нэг хүмүүс буруу ойлгоод яриад байна шүү дээ. Тэр биш. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд ч гэсэн халдашгүй байдлын зарчим бол үйлчилдэг. Тэртэй уялдаатайгаар хийгдсэн асуудал.

Адьяаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяаа:** Би асуулт асуухгүй. Үг хэлье. Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зөв. Бид нар өнөөдөр ёс зүй хууль шүүхийн дээдлэх зарчмын тухай ярьж өнөөдөр явж байгаа. Нөгөө талаасаа бид баталсан хуулиа хамгаалахын тулд бид нарын зөв байсан гэдэг ойлголтыг өгөхийн тулд энд тэндээс гадна, дотнын янз бүрийн ийм юм яриад энийг хамгаалах ийм ойлголт байж болохгүй. Өнөөдөр иргэдийн төлөөлөл болж, тэднийг төлөөлнө гэсэн тэр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон нөхцөлд тэр хүн иргэдийн хуралгүйгээр өөрөө ёс зүйгээрээ огцордог тухай асуудлыг энэ хуульд оруулж өгөх ёстой. Тэгээд дээр нь бид нар яриад байна л даа. Хэлэлцэнэ гэдгийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэг тухай асуудлыг энд буруу юм орсон юм шиг ойлголтыг тайлбарлаад энийг тойрч тайлбарлаад байна. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар шүүхийн шийдвэр эцсийн байна гэдэг энэ зарчмыг бид нар алдагдуулж тайлбарлаж байна шүү дээ. Шүүхийн шийдвэрийг хэлэлцэнэ гэсэн үг биз дээ энэ чинь. Харж аваад үзэхэд иргэдийн Төлөөлөгчдийн хурал хэлэлцэнэ гэдэг чинь ийм ойлголт байна шүү дээ. Тэгэхээр энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь хууль дээдлэх зарчим, шүүх, хуулийн өмнө тэгш байх зарчим, дараа нь төрд итгэх итгэл алдарсан, төрийн эрх барих дээд байгууллага Монгол Улсын Засгийн газраас ёс зүй, сахилга, хариуцлага, төрийн нэр хүндийн асуудал, ард түмний төлөөлөл болсон хүмүүсийн асуудлыг ярьж байгаа үед өнөөдөр Их Хурал гэмт

хэрэг үйлдсэн хүмүүсийг хамгаална. Цэцийн дүгнэлт зөв байна, буруу байна. Ингээд ийм байдлаар ярих нь та нар бас олон түмний өмнө өөрсдөө эвгүй байдалд орно шүү. Энийг би зориуд анхааруулж хэлье. Нэгэнт энэ хүн үнэхээр иргэдийн төлөөлөл болж гараад гэмт хэрэг үйлдсэн юм бол тэрийг нь нэн даруй шийдвэрлэдэг ийм хууль, эрх зүйн орчныг Улсын Их Хурал ч бай, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ч бай энийг бид хуульдаа суулгаж өгөх ёстой. Гэмт хэрэг үйлдсэн нь бүх шатны шүүхээр тогтоогдсон хүмүүстэй бид нар халдашгүй байдал гэдэг ч юм уу иргэдийн төлөөлөл гэдэг утгаар асуудлыг ярих нь хамгийн өөрсдөө энэ Улсын Их Хурал ёс зүйгүй байдал гаргаж, энийг хамгаалж байгаа хүмүүс ёс зүйгүй байна гэдгээ ард түмэнд харуулна шүү. Ийм учраас энд бид үнэхээр хууль, шүүхийн өмнө тэгш байх, хууль дээдлэх зарчмыг биелүүлэх, иргэд яриад байгаа төрийн нэр хүнд унасан, төрд ажиллаж байгаа хүмүүсийн ёс зүй, сахилга, хариуцлагын асуудлыг ярьж байгаа үед гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг хамгаалах, тэдний төлөөлөл гэдэг нэрийн дор ийм юм ярих нь боломжгүй асуудал. Ийм учраас тэр шүүхийн шийдвэр эцсийн байна. Ер нь шүүхийн шийдвэрийг өнөөдөр хэн ч шүүхгүй гээд Үндсэн хууль дээр заасан байгаа шүү дээ. Ийм учраас цэцийн дүгнэлтийг.../минут дуусав/

**Ж.Сүхбаатар:** Гэхдээ энэ юу шүү. Адьяаа гишүүний хэлж байгаа дээр ер нь манай нэгжийн хууль ч бай, Их Хурлын хууль дээр бол адилхан зарчмаар томъёологдсон, хуульчлагдсан. Тэр бол шүүхийн шийдвэрийг авч хэлэлцэж байгаа. Шүүх бол гэм буруутай гээд өөр ямар ч хэрэг дээр холбогдуулаад гэмт хэрэг үйлдсэн эсэхийг нь тогтоож байгаа. Тухайн төлөөллийн байгууллага нь тэр хүний бүрэн эрхийг цуцлах гэж байгаа, гэм буруутай гэдгийг тогтоож байгаа шүүхийн шийдвэрийг авч хэлэлцэж байгаа биш. Тэр дээр шүүхийн шийдвэр дээр үндэслээд бүрэн эрхийг нь цуцлах тухай асуудал чинь тусдаа

асуудал байгаа. Тэгэхээр Мөнхбаатар гишүүн ч гэсэн хэлсэн шүү дээ. Нөхөн сонгууль гээд тэр чинь тогтоол эгүүлэн татагдана шүү дээ. Тэр чинь огцрохгүй л дээ манайх томилогдсон албан тушаалтнуудыг огцруулдаг. Ийм сонгуульт төлөөлөгч нарыг эгүүлэн татдаг. Эгүүлэн татсан тогтоол заавал гарж байж тэр тогтоол гарсны үндсэн дээр нөгөө нөхөн сонгууль чинь зарлах асуудал ч юм уу дараагийн юмнууд нь хөврөх ёстой. Тэгэхгүй шүүхийн шийдвэр гарсан юм чинь гээд тогтоол гаргахгүй орхиж болохгүй. Эгүүлэн татаж, тэр хүний мандатыг цуцлахгүйгээр тэгэхээр дараагийн юм явагдахгүй болно. Тийм учраас энийг Адышаа гишүүн тайлбарыг нь ойлгохгүй бол түрүүний хэлдэг тайлбар яг биш шүү.

Гишүүд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, хариулт авч дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулж үг хэлэх гишүүд нэрээ өгөх үү. Сэргэлэн гишүүн.

**Ц.Сэргэлэн:** Би энэ цэцийн дүгнэлттэй холбогдуулж өөрийнхөө байр суурийг илэрхийлье гэж бодлоо. Ер нь бол маргаан үүсээд байгаа нөхцөл бол хууль өөрөө хоёрдмол утгатай, яаж ч тайлбарлаж болохуйц, ямар өнцгөөс энэ асуудалд хандах вэ гэдэг ийм хуулийн өөрийнх нь найруулга, үг эдгээрээс болсон юм болов уу гэж би хараад байна. Өөрөөр хэлбэл тэр хэлэлцэн гэдэг үг орсон, шийдвэрлэнэ гэдэг үг 2 чинь өөрөө маш олон агуулгыг илэрхийлдэг ийм үг. Шийдвэрлэнэ гэдэг чинь шийдвэр гаргана гэсэн үг. Ямар ч шийдвэр гаргаж болно гэсэн үг. Дэмжинэ, дэмжихгүй гэдгээс эхлээд. Хэлэлцэнэ гэдгээр юу гэдэг юм өөрийнхөө ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх энэ өнцгөөс нь асуудалд хандаж болзошгүй гэж би ойлгоод байгаа юм. Өөрөөр хэлбэл хэлэлцэж байна гээд яваад байдаг. Тэгээд л хурал хойшиллоо, завсарлалаа, ирц бүрдсэнгүй. Энэ нөгөө шүүхийн шийдвэр нэн даруй хэрэгжих учиртай тэр процессыг алдагдуулаад байна уу гэсэн ойлголт нэгдүгээрт

харагдаад байгаа юм. Ер нь бол хууль өөрөө ямар нэгэн салаа утгагүй, нэг мөр ойлгогдохуйц маш тодорхой байх ёстой. Ийм байсан тохиолдолд энэ маргаан үүсэхгүй. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэрийг нэгдүгээрт эцсийн байна. Хоёрдугаарт шүүхийн шийдвэрийг бүх субъектүүд нэг мөр хэрэгжүүлнэ. Гуравдугаарт нэн даруй хэрэгжүүлнэ гэсэн энэ Үндсэн хуулийн суурь агуулгыг хэрэгжүүлэхэд энэ нэгжийн хуульд орсон энэ 2 үг, өгүүлбэрүүд салаа утга илэрхийлснээс болоод асуудал үүсээд байгаа юм болов уу гэж би харж байгаа юм. Ийм учраас бид цаашидаа ч гэсэн ер нь ямар ч хуулийг хэлэлцэхдээ энэ талаас нь анхаарч үзэх.

Хоёрдугаарт ер нь энэ маргаан ахиад л цаашаа эцэс төгсгөлгүй үргэлжилнэ. Яагаад гэвэл энэ бүх шатны иргэдийн хурлууд шүүхийн шийдвэр яаж гарснаас шалтгаалаад яг тэр хэлэлцэн, шийдвэрлэнэ гэдэг үг дээр тоглолт хийгээд л ингээд яваад байх ийм байдал цаашидаа бол үргэлжлэх боломжтой. 2013 онд нэг сумын иргэдийн Хурлын тогтоол гарсан байдаг юм байна лээ. Би харж байсан. Шүүхийн шийдвэрийг хүлээн авах боломж байхгүй. Тогтоолыг шүүхэд танилцуул. Хувийг иргэнд гэсэн. Магадгүй манай зарим иргэдийн хурлууд энэ хуулийн салаа утгатай үг, өгүүлбэрийг ашиглаад иймэрхүү байдлаар асуудалд хандаад байхыг цаашидаа үгүйсгэхгүй. Тэгэхээр би бол нэгэнт энэ асуудал хөндөгдсөн дээр энэ нэгжийнхээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад, энэ салаа утгыг байхгүй болгоод тэр Үндсэн хуулийнхаа суурь заалтыг нэг мөр хэн ч түрүүн Бат-Амгалан гишүүн хэллээ. Нэг мөр ойлгодог болох тухай ойлголт. Өөр өөрийн өнцгөөр тайлбарлаад байдаггүй тухай ойлголт. Өөр өөр өнцгөөс асуудалд хандах боломж олгохгүй, хууль бол ерөөсөө тас няс, түс тас ийм л байх ёстой.

Уншсан бол ойлгосон. Ер нь бол манай хуулийн зарчим байж байгаа шүү дээ. Хуульд юу гэж бичсэн байна.

Түүнийг л яс дагаж мөрдөх ёстой. Цаасан дээр хараар бичсэнийг гэж байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийн энэ суурь заалтыг ямар ч тохиолдолд хэрэгжүүлдэг байхаар энэ хуулиа нэмэлт, өөрчлөлт оруулаад засаад явах нь цаашидаа дахин дахин маргаан гарах энэ үүд хаалгыг хаах боломжтой юм болов уу гэж харж байна. Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах, авахгүйгээс эс хамаараад хуульдаа бид зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулж энийг нэг мөр болгох нь зүйтэй. Ийм салаа утгагүй болгох нь зүйтэй. Тэгээд өөр өөрийн өнцгөөс ялангуяа энэ чинь улс төр шүү дээ. Ялангуяа энэ иргэдийн Хурал чинь өөрөө сонгогддог төлөөллийн байгууллага учраас улс төрийн өнцгөөс асуудалд хандаад байдаг. Ийм учраас энэ асуудлыг ерөөсөө л нэг мөр шүүхийн эцсийн шийдвэр гарсан л бол түүнийг хэрэгжүүлдэг байхаар хуульчлах нь зүйтэй гэсэн зарчмын байр суурийг илэрхийлье гэж бодож үг хэлж байгаа юм. Баярлалаа.

**Ж.Сүхбаатар:** Би итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд сүүлд нь хэлэхэд яг энийг хүлээж аваад энэ ер нь зүгээр зөрчсөн юм нь буруу байна гэх юм бол Их Хурлын гишүүдийн асуудал бол Их Хурлын тухай хуулийн 10.3-ын заалт агуулгаараа хөндөгдөх л болж байгаа юм. Их Хурлын гишүүдийг бол чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг бол Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд гишүүд илээр саналаа гаргаад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно гэсэн заалт байгаа. Үндсэн хуульд бол яах вэ шүүх тогтоовол шууд эгүүлэн татна гээд. Тэгэхээр ер нь яагаад хэлэлцэнэ гэдэг үг цаашидаа орсон юм, салаа утгатай явсан гэхээр парламентын эрх зүй дээр ер нь заагдахад зарим тохиолдолд торгох ял авсан хүн бол жишээлбэл төлөөлөгчийн мандатыг эвдэхгүйгээр аваал үлдэж болох талтай л байхгүй юу. Шоронд

ороогүй, өөр гэмт хэрэг үйлдсэн гээд ял авсан байлаа гэж бодоход. Яагаад гэвэл энэ 2 тусдаа ойлголт байгаа. Нэг нь төлөөлөх мандатыг шүүхийн шийдвэрийг үндэслээд мандатыг цуцлах, эс цуцалж үлдээж болдог. Ер нь сүүлийн үед бол тийм ойлголт байхгүй болсон. Хуучин бол юу гэж онолын арга зүй дээр заадаг байсан гэхээр зарим хөнгөн ял, гэмт хэрэг дээр эрүүгийн гэмт хэрэг дээр ял авсан хүмүүс төлөөлөгчийнхөө мандатыг эвдүүлэхгүйгээр явж байж болно гэдэг тэр логик байдаг байсан. Энэ дээр нэг болгоомжтой судалгаа юу байдаг гэхээр шүүх эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдлийнхээ төлөөллийн мандатыг шууд эвдээд яваад байж болох уу үгүй юу гэж. Тэр хүн чинь гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь ажилтайгаа ихэнх нь холбоогүй гэмт хэрэг үйлдэгдэж болох байгаа байхгүй юу. Жишээлбэл албан үүрэгтэйгээ холбоогүйгээр өөр ямар нэгэн зөрчил дээр авто тээврийн осол ч гэдэг юм уу янз бүрийн юм гаргалаа гэж бодоход тэр нь яах вэ гэж. Тэгэхээр энэ зүгээр ийм асуудлууд онолын ч гэдэг юм уу, практикийн асуудлууд байгаа.

Тэгэхээр саяны ярьж байгаа асуудлуудаар хийх юм бол манай Их Хурлын тухай хуулийн нэг заалт ч гэсэн зөв үү, буруу юу гэдэг асуудал руу ороод хэлэлцэх ёстой юмыг шүүхийн шийдвэр гарсан юм чинь шууд тогтоол гарга гээд бид нар хэлэлцэхгүйгээр яах юм явах юм уу үгүй юу гэдэг асуудал үүсэх юм байгаа юм. Гэхдээ түрүүн Мөнхбаатар гишүүний хэлдэг асуудал байгаа. Тогтоол заавал хэлэлцэж байж тогтоол гарна шүү дээ. Тэгэхээр нэг тогтоол ямар ч байсан гарч байж дараа нь тэр сонгууль зарлагдаж таарна гэх мэтийн юм байгаа. Энэ болгон нээлттэй. Тал талаас нь бодох ёстой ийм асуудал байгаа.

Ингээд цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулья. 2 санал хураалт байгаа юм байна.

1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Томъёолол нь зүйтэй гэж байгаа. Зөвшөөрсөн 3 буюу 25.0 хувь нь зөвшөөрсөн байна. Татгалзсан 9 буюу 75 хувь нь татгалзсан байна. Энэ томъёолол хүлээж авсангүй.

Дараа нь. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Хурлын төлөөлөгчийг энэ хуулийн 41.1.2, 41.1.4, 41.1.5-д заасан тохиолдолд чөлөөлөх, 41.1.3, 41.1.6, 41.1.7-д заасан тохиолдолд огцруулах тухай асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэж заасны “... 41.1.3, ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн 2 буюу 16.7 хувь, татгалзсан 10 буюу 83.3 хувь нь татгалзсан байна. Ингэхээр энэ томъёоллыг хүлээж авахгүй гэж шийдвэрлэлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын Үндсэн

хуулийн цэцийн 2023 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Э.Бат-Амгалан гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

11.23 цаг.

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**  
**Э.СУВД-ЭРДЭНЭ**